



МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН
АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ДОРЖДЭРЭМ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/380
Аудитын гэрчилгээ
танай -ны № -т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\022\SAQ57.Docx
УХА0122 070534



МОНГОЛ-GERМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас:
Цахим хаяг:

Аудитор: Ж.Болормаа
Утас:
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дугаар сарын 25-аас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөж хэрэгжүүлэв.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 21-нд аудитад ирүүлсэн болно.

Аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд Үндэсний аудитын газарт хүлээлгэж өгөв.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь Монгол ба Герман улсуудын Засгийн газруудын санаачилгаар 2011 онд үүсгэн байгуулагдсан Төрийн өмчийн их сургууль (төсвийн байгууллага) юм. Анх 2011 онд тус их сургуулийг байгуулах санаачилгыг хоёр улсын тэргүүнүүд тохиролцсоноор 2012 оны намар анхны элсэлтээ авсан байна.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль байгуулах талаар Харилцан ойлголцлын санамж бичигт Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам болон Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг нь 2012 оны 12 дугаар

сард гарын үсэг зурсан. Ингэснээр уг их сургуульд суралцагчид нь Герман улсын дээд боловсролын стандартын сургалтын хөтөлбөрт хамрагдаж, 3 мэргэжлээр бакалавр, инженерийн бэлтгэл хөтөлбөрөөр суралцахаар болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 95 тоот тогтоолоор Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль байгуулах шийдвэрийг гаргаж 2013-2014 оны хичээлийн жилээс сургалтын үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

Тус сургуулийн гол зорилго эдийн засгийн тогтвортой хөгжлийн төлөө олон улсын сайн туршлага, тэргүүлэх стандартыг Монголд хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд сургуулийн нэг онцлог нь үйлдвэрийн бодит практиктай нягт уялдсан сургалтанд оршино.

Тус сургуулийн хотхоныг 2014 онд ашиглалтанд оруулсан бөгөөд уг хотхон нь Улаанбаатар хотын Налайх дүүрэгт байрладаг.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 159 тоот Үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх тухай тогтоолоор техник технологийн шаталсан сургалттай тус сургуулийн мэдэлд Оюутолгой ХХК-ийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа цогцолбор барилгыг шилжүүлсэн байна.

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ” гэж уг дээд сургуулийн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн захирагчтай байна” гэж заасны дагуу Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн захирал нь Төсвийн шууд захирагчийн үүргийг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасны дагуу гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн 2016 оны төсвийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ)-ны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд тус сургуулийн үйл ажиллагаатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэн гаргах заавар, журам, аргачлалыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын

уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилуудыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах шатанд байна. Тиймээс УСНББОУС-тай нийцүүлэн Сангийн сайдаас баталсан төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглах заавар, журам, аргачлалтай уялдуулсан санхүүгийн программын хүрээнд ажиллаж байна.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох төвийн Acolous 3.0 санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу гүйцэтгэсэн байна.

Материаллаг байдал:

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн материаллаг байдлын түвшинг тогтоохдоо нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь тохиромжтой гэж үзэв. Төлөвлөлтийн үе шатанд нийт орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийг суурь үзүүлэлт болгон материаллаг байдлын түвшинг тооцоход эдгээр үзүүлэлтээс тооцсон түвшин нь хэт өндөр байгаа тул нийт зардлыг материаллаг түвшний үнэлгээнд суурь үзүүлэлт болгохоор сонгосон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ. Тус сургуулийн санхүүгийн тайлангийн материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувиар буюу 25.6 сая төгрөг гэж тодорхойлов. /ТАБ-СТА-А-2/. Агуулгын хувьд буюу шинж чанарын хувьд материаллаг аливаа зүйл байхгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс тус сургуулийн дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу БСШУСЯ-ны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,563.3 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанаас 360.1 сая төгрөгийн, нэмэлт 102.7 сая төгрөгийн, нийт 2,026.2 сая төгрөгийн орлого олжээ. Үүнээс төсвийн санхүүжилтийн урсгал зардалд 2,058.1 сая

төгрөгийн төсөв батлагдсанаас 1,982.1 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 75.9 сая төгрөгөөр хэмнэсэн үзүүлэлттэй байна. 2016 онд зарцуулаагүй үлдэгдэл 44.0 сая төгрөгийг төсөвт буцааж төвлөрүүлсэн байна.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн гүйцэтгэл нь нийт дүнгээрээ хэмнэлттэй үзүүлэлттэй байгаа боловч байрны түрээсийн зардал 5.4 сая төгрөгөөр, тээвэр шатахууны зардал 2.0 сая төгрөгөөр, шуудан холбоо интернетийн зардал 9.2 сая төгрөгөөр, урсгал засвар 1.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 54.3 сая төгрөгөөр, мэдээллийн технологийн зардал 1.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 0.8 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн үзүүлэлттэй байна. Эдгээр нь Сангийн сайдын 2010 оны 10 дугаар сарын 229 тоот, 2010 оны 12 дугаар сарын 275 тоот тушаалуудын дагуу зохицуулагдсан байна.

Сургуулийн үйл ажиллагааны орлогоор 495.1 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлого төвлөрүүлэхээс 360.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 135.0 сая төгрөгөөр буюу 72.7 хувиар тасалсан байна. 2015-2016 оны хичээлийн жилд 100 оюутан, 2016-2017 оны хичээлийн жилд 120 оюутан элсүүлэхээр төлөвлөсөн боловч 77-102 оюутан элсүүлэн нь орлого дутуу бүрдэхэд нөлөөлсөн байна.

Шилэн дансны мэдээлэл:

Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийг бодитоор хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас 2014 онд 384 тоот тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баталсан. Энэхүү журмын 7 дугаар зүйлд заасны дагуу тус сургууль нь Шилэн дансны мэдээллийг <http://www.gmit.edu.mn/transparent/> гэсэн их сургуулийн албан ёсны цахим хуудаснаа байршуулсан ба журмын 3 дугаар зүйлд заасны дагуу төсвийн хөтөлбөр/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, шилэн дансны хууль эрх зүй гэсэн төрлөөр ангилан байршуулсан ба санхүүгийн холбогдох мэдээллүүдийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд тогтмол оруулж тайлагнаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 4, нарийвчилсан 4 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: авлага, өр төлбөрийг барагдуулаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй зэрэг зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний материаллаг түвшнээс дээш дүнтэй (мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, сургалтын төлбөрийн орлого, цалин хөлсний зардал, түлш халаалтын зардал, байрны түрээсийн зардал, бичиг хэргийн зардал, тээвэр шатахууны зардал, шуудан холбоо интернетийн зардал, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, даатгалын үйлчилгээний төлбөр, албан томилолтын зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийлгэх зардал, хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг дансдын) ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа /ТАБ-СТА-В-3/. Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт мөнгөн хөрөнгийн 81.0 хувь, бараа материалын 60.0 хувь, эргэлтийн бус хөрөнгийн 3.0 хувь, сургалтын төлбөрийн орлогын 36.0 хувь, зардлын 56.0 хувийг тус тус эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтанд хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант хугацааны эцэст 52,800.3 мянган төгрөгийн авлагын, 38.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. (Авлага ба өр төлбөрийн талаар Менежментийн захидалд дэлгэрэнгүй тусгасан.)

Шийдвэрлэсэн: Авлага, өр төлбөрийг барагдуулах талаар зөвлөмж өгөх,

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх талаар өмнөх аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй, сургуулийн удирдлага нь уг баримт бичиг боловсруулагдсан, хяналтын шатанд явж байгаа, батлагдаж мөрдөгдөөгүй гэсэн тайлбар өгсөн.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг даруй боловсруулж дуусгаж мөрдөх талаар зөвлөмж өгөх,

3. Дотоод хяналтын алба нэгжгүй, дотоод хяналтын ажилтангүй, дотоод хяналтын бодлого горимгүй байна.

Шийдвэрлэсэн: Дотоод хяналтын тогтолцоог бий болгох талаар зөвлөмж өгөх,

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад хууль, дүрэм, стандарт, заавар журам мөрдөөгүйгээс залруулах материаллаг бус хэмжээний алдаа тогтоогдоогүй боловч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, дотоод хяналтын системийг боловсруулах зэргийг залруулах боломжгүй байсан.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

ХБНГУ-ын Засгийн газраас уг төслийг хэрэгжүүлэхэд зарцуулж байгаа санхүүжилтийг Монгол Улсын тал зардлаар хүлээн авах эсэх нь тодорхойгүй байгаа ба цаашид Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн бүртгэл, тайланд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй хэвээр байна. Мөн уг санхүүжилтийг төгрөгт хөрвүүлэхэд ашиглах ханшны талаар 2 улсын хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичигт тусгаагүй тул санхүүжилтийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэхэд хүндрэл үүсч байгаа ба энэ талаар Германы талд санал явуулсан боловч хариу ирүүлээгүй байна гэсэн тайлбарыг тус сургуулийн удирдлага өгсөн.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд байна гэж тодорхойлж байна.

- Авлага, өр төлбөрийн барагдуулалт
- Засгийн газрын оруулсан капиталын бүртгэл, тайлагнал
- Дотоод хяналтын тогтолцоо
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулалт ба мөрдөлт
- ХБНГУ-ын Засгийн газраас төслийг хэрэгжүүлэхэд зарцуулж байгаа санхүүжилтийн хүлээн зөвшөөрөлт ба ашиглах ханш

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 52.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Зөрчилд зөвлөмж өгсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд 1 зөвлөмж хэрэгжсэн, 1 зөвлөмж нь дутуу хэрэгжилттэй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх талаар өгсөн зөвлөмж нь дутуу хэрэгжилттэй буюу одоогийн байдлаар тус сургууль нь уг баримт бичгийг боловсруулж байгаа гэсэн тайлбар өгсөн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудсыг хавсаргав.



МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Асуудал 2

Авлага, өр төлбөр

Асуудал 3

Дотоод хяналт

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бэлтгэсэн бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1:**Тэргүүлэх ач холбогдол №1****Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг****Ажиглалт**

Өмнөх аудитаар тус сургуульд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг захирлын зөвлөл, удирдах зөвлөлөөр яаралтай батлуулан мөрдөх,

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүү бүртгэлийн холбогдолтой болон бусад хууль дүрэм, журам заавар хэрэгжихгүй байх,

Төсвийн захирагчийн хариу

Уг баримт бичгийг боловсруулж дуусан захирлын зөвлөлд танилцуулахаар явуулсан хариу ирээгүй байгаа, 2017 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулж мөрдөх болно.

Авлага, өр төлбөр**Ажиглалт**

Тайлант хугацааны эцэст 52,800,319.07 төгрөгийн авлагын, 38,016.00 төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Авлага нь дараах авлагуудаас бүрдсэн:

- Хөтөл-Цемент Бейзмент ХХК (3 оюутны төлбөр) 8,750,000 төгрөг – өмнөх тайлант хугацаанд үүссэн ба 2016 онд хөдөлгөөн өөрчлөлт ороогүй.
- Дархан төмөрлөг ХХК (5 оюутны төлбөр) 24,500,000 төгрөг – өмнөх тайлант хугацаанд үүссэн ба 2016 онд хөдөлгөөн өөрчлөлт ороогүй.
- Бусад оюутны сургалтын төлбөр 15,286,500 төгрөг.
- Цайны газрын түрээсийн төлбөрийн авлага 3,757,500 төгрөг – өмнөх тайлант хугацаанд үүссэн ба 2016 онд хөдөлгөөн өөрчлөлт ороогүй.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны авлага 16,001.02 төгрөг
- Хувь хүний орлогын албан татварын тооцооны авлага 490,318.05 төгрөг.

Өр төлбөрийн үлдэгдэл нь тэтгэврийн насны ажилтны цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийг буруу хувь хэмжээгээр суутгаснаас үүссэн.

Эрсдэл

Санхүүгийн тайлагналтай холбоотой хууль тогтоомж зөрчигдөх, төсвийн мөнгөн орлого дутуу бүрдэх, барагдуулах боломжгүй авлага, өр төлбөр үүсэх, төсвийн хөрөнгө шамшигдах, зарга маргаан үүсэх.

Зөвлөмж

Авлага, өр төлбөрийг яаралтай барагдуулах арга хэмжээ авах, төсвийн холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, төсвийн мөнгөн орлогыг цаг хугацаанд нь бүрэн бүрдүүлж байх,

Төсвийн захирагчийн хариу**Сургалтын төлбөрийн авлага:**

Дархан төмөрлөг ХХК–тай гэрээ байгуулсан оюутны сургалтын төлбөр мөнгөгүй гэх шалтгаанаар огт төлөгдөөгүй.

Бэйзмэнт ХХК нь Хөтөл цементтэй нэгдсэнээс шалтгаалан захирал солигдсон тул төлбөрийн асуудлыг хойшлуулсан. Сургуулийн хуульч эдгээр асуудлаар хэд хэдэн удаа холбоо барих, томилолтоор явсан ч нааштай үр дүн гараагүй.

Цайны газрын түрээсийн авлага:

2015 онд Хүйс гол хан хөхий ХХК-тай гэрээ байгуулан 150.3м.кв талбайг 1 м.кв-ыг 2,500

төгрөгөөр бодож сарын 375,750 төгрөгөөр сургуулийн цайны газрыг түрээслүүлсэн болно. 10 сарын түрээсийн төлбөр болох 3,750,750₮ одоо болтол төлөгдөөгүй байна. Үйлчлүүлэгч цөөн байсан тул хоолны материалын зардлаа л зөвхөн олж ажилчдаа цалинжуулж чадахгүй байсан ба түрээсийн төлбөрийг төлөх бололцоогүй байна гэсэн тайлбар өгч байсан. Сургуулийн хуульчтай хэд хэдэн удаа уулзсан, мөн албан бичиг ирүүлсэн ба цалингийн зардлын өр төлбөрөөсөө гараагүй байна, мөнгө олдвол төлнө гэсэн хариу өгсөн. 2016 оны 4 дүгээр улиралд холбогдох гэж удаа дараа оролдоод бүтэлгүйтсэн.

Өр төлбөр:

Тус их сургууль нь 2016 оны жилийн эцсийн тайлангаар 38,016 төгрөгийн цалингийн өглөгтэй байгаа ба жилийн эхэнд санхүүгийн программ, Excel файл хоорондын тооцооллоос үүссэн өглөг юм. Санхүүгийн программын мэдээллийг жилийн эцсийн санхүүгийн тайлан гарсны дараа архивлаж, дараагийн оны шинэ бүртгэл эхэлдэг тул 2016 оны 1 сард цалин бодогдох үед санхүүгийн тайлан бэлтгэх үе таарсан тул Excel дээр бодогдсон. Өөрөөр хэлбэл, Excel файл дээр 2016 оны 1 сарын цалин бодохдоо тэтгэврийн ангилалд багтсан багшийн цалингаас НДШ-ийг энгийн ажилтнаар суутгасан байсан. Дараа нь санхүүгийн программд нөхөж шивэхэд зөрүү гарч, өглөгийн дансанд бүртгэсэн.

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3:**Тэргүүлэх ач холбогдол №1****Дотоод хяналт****Ажиглалт**

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь дотоод хяналтын алба нэгжгүй, дотоод хяналтын ажилтангүй, дотоод хяналтын бодлого горимгүй байна.

Зөвлөмж

Байгууллагын бүтцэд дотоод хяналтын алба нэгжийг бий болгох, дотоод хяналтын ажилтныг тусгайлан томилж ажиллуулах, дотоод хяналтын бодлого горим боловсруулж мөрдөх,

Эрсдэл

Тусгайлсан дотоод хяналтгүйгээс бүртгэл, тайлагналд алдаа зөрчил үүсэх, хууль тогтоомж, стандарт, заавар журам зөрчигдөх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

Балансын зүйл	2015.12.31	2016.12.31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	1,343.00	1,343.00
Кассанд байгаа бэлэн мөнгө		
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	1,343.00	1,343.00
АВЛАГА	66,860,500.00	52,800,319.07
Төлбөртэй үйлчилгээний авлага	63,103,000.00	48,536,500.00
Бусад авлага	3,757,500.00	4,263,819.07
БАРАА МАТЕРИАЛ	996,058,392.84	991,587,381.31
Түүхий эд материал	850,950,775.54	859,041,925.54
Хангамжийн материал	145,107,617.30	132,545,455.77
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,062,920,235.84	1,044,389,043.38
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,164,290,788.89	14,015,020,496.85
Биет хөрөнгө	14,163,441,038.84	14,007,163,746.76
Барилга, байгууламж	12,980,886,941.00	12,980,886,941.00
Хуримтлагдсан элэгдэл	(377,859,202.44)	(702,381,375.96)
Авто тээврийн хэрэгсэл	205,743,000.00	399,310,674.00
Хуримтлагдсан элэгдэл	(30,597,050.02)	(67,301,989.54)
Машин, тоног төхөөрөмж	686,462,928.00	768,184,836.30
Хуримтлагдсан элэгдэл	(170,171,699.65)	(322,857,241.35)
Тавилга, аж ахуйн эд хогшил	548,218,985.98	615,818,670.87
Хуримтлагдсан элэгдэл	(97,481,313.08)	(161,003,300.05)
Бусад үндсэн хөрөнгө	304,407,805.00	304,407,805.00
Хуримтлагдсан элэгдэл	(40,881,021.95)	(73,057,778.51)
Номын фонд	154,711,666.00	265,156,505.00
Биет бус хөрөнгө	849,750.05	7,856,750.09
Програм хангамж	-	7,260,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Биет бус хөрөнгө	1,265,000.00	1,265,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(415,249.95)	(668,249.91)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,164,290,788.89	14,015,020,496.85
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,227,211,024.73	15,059,409,540.23
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	-	38,016.00
Ажиллагчидтай холбогдсон өглөг		38,016.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	38,016.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл		
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	38,016.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	12,620,886,941.00	12,620,886,941.00
Хуримтлагдсан үр дүн	2,606,324,083.73	2,438,484,583.23
Өмнөх үеийн	2,831,032,437.67	2,606,324,083.73
Тайлант үеийн	(224,708,353.94)	(167,839,500.50)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	15,227,211,024.73	15,059,371,524.23
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	15,227,211,024.73	15,059,409,540.23

МОНГОЛ-GERМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,179,917,182.55	2,393,627,783.19
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	568,955,024.55	727,562,242.19
Үндсэн үйл ажиллагааны орлого	373,840,604.00	343,789,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	3,757,500.00	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	191,356,920.55	383,773,242.19
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,610,962,158.00	1,666,065,541.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,552,181,660.00	1,563,323,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	58,780,498.00	102,742,041.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,404,625,536.49	2,561,467,283.69
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	2,238,393,552.13	2,517,437,490.71
Цалин,хөлс болон нэмэгдэл урамшил	1,135,747,706.00	1,314,365,011.80
Цалин	1,135,747,706.00	1,314,365,011.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,956,514.99	142,259,015.43
Тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэл	102,200,051.79	118,073,146.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,756,463.20	24,185,869.43
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,829,538.36	187,985,485.36
Гэрэл, цахилгааны зардал	25,329,476.72	35,462,447.40
Түлш, халаалтын зардал	101,014,480.64	109,765,681.96
Цэвэр, бохир усны зардал	8,077,729.00	6,064,104.00
Байрны түрээс	34,407,852.00	36,693,252.00
Хангамж, бараа материалын зардал	41,397,118.35	62,020,144.38
Бичиг хэргийн материал	7,304,910.00	16,005,925.00
Тээвэр, шатахууны зардал	12,481,428.00	13,548,400.00
Шуудан холбоо, интернетийн зардал	18,815,001.35	18,821,909.01
Ном хэвлэлийн зардал	212,300.00	7,757,632.00
БҮТЭЗ-ийн зардал	2,583,479.00	5,886,278.37
Нормативт зардал	1,902,543.65	1,272,240.00
Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал	1,902,543.65	1,272,240.00
Эд хогшил, урсгал засварын зардал	14,431,645.00	26,426,119.59
Багаж хэрэгслийн зардал	2,070,750.00	259,800.00
Урсгал засварын зардал	12,360,895.00	26,166,319.59
Томилолт, зочны зардал	11,919,265.00	7,070,447.00
Гадаад томилолтын зардал	10,270,200.00	-
Дотоод томилолтын зардал	1,649,065.00	7,070,447.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	85,810,498.00	98,548,511.86
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	66,216,029.00	86,157,684.86
Аудитын үйлчилгээний зардал		5,000,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал	18,914,969.00	1,866,220.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	338,000.00	4,961,707.00
Тээврийн хэрэгслийн татвар	341,500.00	562,900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	653,398,722.78	677,490,515.29
Бусад зардал	3,735,895.00	878,911.11
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	81,875,923.09	66,747,205.95
Элэгдлийн зардал	567,786,904.69	609,864,398.23
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,231,984.36	44,029,792.98
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	166,231,984.36	44,029,792.98
Төвлөрүүлэх шилжүүлэг	166,231,984.36	44,029,792.98
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(224,708,353.94)	(167,839,500.50)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
НИЙТ ҮР ДҮН	(224,708,353.94)	(167,839,500.50)

МОНГОЛ-GERМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
1	2	3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,932,339,762.00	2,073,557,655.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	321,377,604.00	402,902,220.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	321,377,604.00	402,902,220.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	321,377,604.00	360,105,500.00
Туслах үйл ажиллагааны орлого		42,796,720.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,610,962,158.00	1,670,655,435.00
Улсын төсвөөс	1,552,181,660.00	1,563,323,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,552,181,660.00	1,563,323,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	58,780,498.00	102,742,041.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		2,000,000.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУБайгууллагаас авсан орлого	38,846,500.00	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,900,000.00	43,784,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,033,998.00	56,958,041.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		4,589,894.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		4,589,894.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	1,860,290,421.54	2,002,153,191.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,860,290,421.54	2,002,153,191.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,694,058,437.18	1,958,123,398.02
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,137,823,161.41	1,318,916,888.72
Цалин	1,017,219,433.41	1,210,048,192.07
Үр дүнгийн урамшуулал	120,603,728.00	108,868,696.65
Нийгмийн хамгааллын шимтгэл	122,194,259.58	142,275,017.24
Тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэл	99,437,796.38	119,278,444.05
Үр дүнгийн урамшуулал	22,756,463.20	22,996,573.19
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	168,829,538.36	188,028,685.36
Гэрэл цахилгааны зардал	25,329,476.72	35,462,447.40
Түлш, халаалтын зардал	101,014,480.64	109,765,681.96
Цэвэр, бохир усны зардал	8,077,729.00	6,064,104.00
Байрны түрээсийн	34,407,852.00	36,736,452.00
Бусад бараа, үйлчилгээний зардал	42,106,653.00	58,169,105.00
Бичиг хэргийн материал	6,661,500.00	10,306,311.00
Тээвэр, шатахууны зардал	11,473,000.00	13,548,400.00
Шуудан, холбооны зардал	18,161,101.35	18,821,909.01
Ном, хэвлэлийн зардал	3,029,200.00	8,239,132.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,781,851.65	7,253,352.99
Нормативт зардал	1,973,300.00	2,400,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,973,300.00	2,400,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	14,308,868.00	16,462,210.00
Багаж техник хэрэгсэл	1,990,478.00	569,850.00
Урсгал засварын зардал	12,318,390.00	15,892,360.00
Томилолт, зочны зардал	12,927,693.00	6,588,300.00
Гадаад албан томилолт	10,270,200.00	
Дотоод албан томилолт	2,657,493.00	6,588,300.00

1	2	3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	69,620,209.00	119,015,840.70
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	68,940,709.00	106,625,013.70
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,000,000.00
Даатгалын үйлчилгээ	338,000.00	4,961,707.00
Тээврийн хэрэгслийн татвар	341,500.00	562,900.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,866,220.00
Бараа үйлчилгээний бусад зардал	124,274,754.83	106,267,351.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	43,604,520.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	118,274,754.83	62,662,831.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,231,984.36	44,029,792.98
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	166,231,984.36	44,029,792.98
Төвлөрүүлэх шилжүүлэг	166,231,984.36	44,029,792.98
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	72,049,340.46	71,404,464.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
Хөрөнгийн орлого		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	(72,048,010.00)	(71,404,464.00)
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	(72,048,010.00)	(71,404,464.00)
Хөрөнгийн бусад зардал		
Урсгал зардлаас хөрөнгө худалдан авсан		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(72,048,010.00)	(71,404,464.00)
САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,330.46	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12.54	1,343.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,343.00	1,343.00

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл	-	-	15,451,919,378.67	15,451,919,378.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,620,886,941.00	-	(12,620,886,941.00)	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,620,886,941.00	-	2,831,032,437.67	15,451,919,378.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(224,708,353.94)	(224,708,353.94)
2015 оны 12-р сарын 30- ээрх үлдэгдэл	12,620,886,941.00	-	2,606,324,083.73	15,227,211,024.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(167,839,500.50)	(167,839,500.50)
2016 оны 12-р сарын 31- ээрх үлдэгдэл	12,620,886,941.00		2,438,484,583.23	15,059,371,524.23

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,343.00		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,058,068,560.00	1,982,141,248.02	75,927,311.98	96.31
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,058,068,560.00	1,982,141,248.02	75,927,311.98	96.31
Бараа, үйлчилгээний зардал	2,058,068,560.00	1,982,141,248.02	75,927,311.98	96.31
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,420,666,000.00	1,314,326,994.72	106,339,005.28	92.51
Үндсэн цалин	1,291,166,000.00	1,205,458,298.07	85,707,701.93	93.36
Урамшуулал	129,500,000.00	108,868,696.65	20,631,303.35	84.07
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,273,260.00	142,275,017.24	13,998,242.76	91.04
Тэтгэврийн даатгал	127,859,940.00	119,278,444.05	8,581,495.95	93.29
Эрүүл мэндийн даатгал	28,413,320.00	22,996,573.19	5,416,746.81	80.94
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,177,800.00	188,028,685.36	17,149,114.64	91.64
Гэрэл цахилгаан	35,497,300.00	35,462,447.40	34,852.60	99.90
Түлш, халаалт	131,023,500.00	109,765,681.96	21,257,818.04	83.78
Цэвэр, бохир ус	7,292,000.00	6,064,104.00	1,227,896.00	83.16
Байрны түрээс	31,365,000.00	36,736,452.00	(5,371,452.00)	117.13
Хангамж, бараа материалын зардал	76,049,700.00	76,273,700.00	(224,000.00)	100.29
Бичиг хэрэг	11,146,200.00	10,306,311.00	839,889.00	92.46
Тээвэр (шатахуун)	11,524,200.00	13,548,400.00	(2,024,200.00)	117.56
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	9,737,600.00	18,821,909.01	(9,084,309.01)	193.29
Ном, хэвлэл	34,918,300.00	26,343,727.00	8,574,573.00	75.44
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	8,723,400.00	7,253,352.99	1,470,047.01	83.15
Нормативт зардал	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	15,017,000.00	16,462,210.00	(1,445,210.00)	109.62
Багаж, техник, хэрэгсэл	444,800.00	569,850.00	(125,050.00)	128.11
Урсгал засвар	14,572,200.00	15,892,360.00	(1,320,160.00)	109.06
Томилолт, зочны зардал	6,588,300.00	6,588,300.00	-	100.00
Дотоод албан томилолт	6,588,300.00	6,588,300.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	59,933,800.00	119,015,840.70	(59,082,040.70)	198.58
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	49,370,900.00	106,625,013.70	(57,254,113.70)	215.97
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	5,000,000.00	4,961,707.00	38,293.00	99.23
Тээврийн хэрэгслийн татвар	562,900.00	562,900.00	-	100.00
Мэдээллийн технологийн зардал	-	1,866,220.00	(1,866,220.00)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	115,962,700.00	116,770,500.00	(807,800.00)	100.70
Бараа үйлчилгээний бусад зардал	-	807,800.00	(807,800.00)	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	115,962,700.00	115,962,700.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,058,448,500.00	1,982,141,248.02	76,307,251.98	96.29
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,563,323,500.00	1,559,410,704.32	3,912,795.68	99.75
Улсын төсвөөс санхүүжих	1,563,323,500.00	1,559,410,704.32	3,912,795.68	99.75
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	495,125,000.00	360,105,500.00	135,019,500.00	72.73
Үндсэн үйл ажиллагааны орлого	495,125,000.00	360,105,500.00	135,019,500.00	72.73
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	62,625,043.70	(62,625,043.70)	-
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,000,000.00	(2,000,000.00)	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,056,521.00	(14,056,521.00)	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	46,568,522.70	(46,568,522.70)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,343.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,343.00		